

БАТЛАВ  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Ц.ЧОГСОМЖАВ

2024 оны 02 дугаар сарын 07

УДИРДАМЖ

2024 оны 02 дугаар сарын 06

Чингис хот

ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨРИЙН ЦЭРГИЙН БОЛОН ХУУЛЬ САХИУЛАХ  
БАЙГУУЛЛАГУУДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “ШИЛДЭГ ЗАЛУУ ОФИЦЕР,  
АХЛАГЧ” ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТУХАЙ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү удирдамжаар Хэнтий аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын шилдэг офицер, ахлагч шалгаруулах (цаашид “тэмцээн” гэх) хамрах хүрээ, зохион байгуулалт, шалгаруулалт, шагнаж урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Тэмцээний зорилго нь Хэнтий аймгийн төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд (цаашид “Байгууллагууд” гэх)-д хамт олноо манлайлж, үр бүтээлтэй ажиллаж байгаа мэргэжлийн ур чадвартай, ёс зүй, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй, шинийг санаачлагч шилдэг офицер, ахлагчийг шалгаруулах, цаашлаад бусад алба хаагчдын ур чадварыг хөгжүүлэх, манлайллыг дэлгэрүүлэх, чадварлаг боловсон хүчин, хүний нөөц бүрдүүлэх, дээрх байгууллагуудын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, байгууллагын болон алба хаагчдын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд оршино.

1.3. Тэмцээний шалгаруулалтад ажлын хэсэг дараах зарчмыг баримтална:

1.3.1. Ил тод, нээлттэй, шударга байх;

1.3.2. Тэмцээнд оролцогчдын ажлын үр дүн, манлайлал, сахилга ёс зүйг дүгнэж бүртгэх;

1.3.3. Тэмцээнд оролцогчдын аюулгүй байдлыг хангаж, ёс зүй, сахилга батыг чанд сахиулах.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Тэмцээнд (Хэнтий аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги, Тагнуулын хэлтэс, Дотоодын цэргийн 830-р тусгай салбар, Шүүх шинжилгээний хэлтэс, Зэвсэгт хүчний 232-р анги, Хилийн цэргийн 0287-р анги) байгууллага тус бүр хошууч, ахмад,

ахлах дэслэгч, дэслэгч, ахлах ахлагч, ахлагч, дэд ахлагч цолтой 40 хүртэлх насны удирдамжийн оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт хангасан эрэгтэй, эмэгтэй офицер, эрэгтэй, эмэгтэй ахлагч нарыг бүрэн хамруулна.

#### Гурав. Оролцогчдод тавигдах шалгуур үзүүлэлт

3.1. Тэмцээнд оролцох “Шилдэг офицер, ахлагч” нь дараах нийтлэг шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

3.1.1. Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад 1 ба түүнээс дээш жил ажилласан байх;

3.1.2. Цэргийн дүрэм болон хууль, эрх зүйн мэдлэгтэй байх;

3.1.3. Сахилга, ёс зүйн зөрчилгүй байх;

3.1.4. Гэмт хэрэг, зөрчилд холбогдоогүй байх (хэрэв гэмт хэрэг, зөрчилд холбогдсон бол шинж чанар, хор уршгийг харгалзан үзнэ)

3.1.5. Эрүүл мэнд, ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн шаардлага хангасан байх;

#### Дөрөв. Бүрдүүлэх материал

4.1. Тэмцээний нэгдүгээр шатанд хамрагдах нийтлэг шалгуур (3.1. дэх хэсэгт заасан) хангасан алба хаагчдын нэрс (судалгаа)-ийг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотор ажлын хэсгийн нарийн бичгийн даргад ирүүлнэ. (Материал ирүүлэх цахим хаяг: [moduchin@gmail.com](mailto:moduchin@gmail.com), мэдээлэл авах утас 86973607)

4.2. Тэмцээнд оролцогч байгууллагууд тэмцээний 2 дугаар шатанд шалгарсан алба хаагчдын материалыг дараах бүрдлээр бүрдүүлнэ.

4.2.1. Ажил байдлын тодорхойлолт;

4.2.2. Төрийн албан хаагчийн анкет;

4.2.3. Сүүлийн 1 жилийн гүйцэтгэлийн үнэлгээний хуудас

4.2.4. Хувь хүний товч танилцуулга (Ажлын хэсгээс боловсруулсан загвараар)

4.2.5. Гэнэтийн ослын даатгалд хамрагдсан байх.

#### Тав. Зохион байгуулалт

5.1. Тэмцээнийг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газраас 3, Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллага бүрээс тус бүр 1 алба хаагчийг ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх баталгаа (Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт) авч ажлын

хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилох ба уг ажлын хэсэг удирдан зохион байгуулна.

5.2. Тэмцээн 2 үе шаттайгаар явагдах ба нэгдүгээр шатны шалгаруулалтыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд байгууллага тус бүрт ажлын хэсэг очиж шалгаруулалтыг зохион байгуулах бөгөөд хоёрдугаар шатны шалгаруулалтыг 2024 оны 09 дүгээр сард нэгдсэн журмаар зохион байгуулна.

5.3. Тэмцээний эхний шатанд байгууллага тус бүрээс оролцож буй алба хаагчдаас сорил авч, тухайн байгууллагын хамгийн өндөр дүнтэй эрэгтэй 2, эмэгтэй 1 офицер, эрэгтэй 2, эмэгтэй 1 ахлагч нарыг хоёрдугаар шатанд тэнцүүлнэ.

5.4. Хоёрдугаар шатанд шалгарсан алба хаагчдын материалыг 2024 оны 03-р сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авах ба хугацаа хэтрүүлсэн болон шаардлага хангаагүй материал ирүүлсэн тохиолдолд хүлээн авахгүй. (Материал ирүүлэх цахим хаяг: [moduchin@gmail.com](mailto:moduchin@gmail.com), мэдээлэл авах утас 86973607)

5.5. Тэмцээний 2 дугаар шатны техникийн зөвлөгөөнийг 2024 оны 09 дүгээр сард Хэнтий аймгийн Хэрлэн суманд шаардлагатай бол цахимаар зохион байгуулна.

5.6. Тэмцээний нээлтийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, тэмцээний хаалт буюу шагнал гардуулах өдрийг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр тус тус зохион байгуулна.

5.7. Тэмцээний явц байдал, оролцогчдын дүн ил тод, нээлттэй, шуурхай байдлаар тэмцээн бүрийн дараа платформд шууд нийтлэгдэж явагдана.

## Зургаа. Шалгаруулалт

6.1. Тэмцээний нэгдүгээр шатны тэмцээнийг 250-260 үгтэй эссэ бичиж, илтгэлд хөрвүүлэн хэлэлцүүлэх (Асуудлаас-шийдэлд сэдэвт), цэргийн бие бялдрын ерөнхий бэлтгэлжилт, нормативт дасгалаар шалгалт, гадаад хэлний мэдлэгийн А1-А2 ( англи хэлний анхан шатны мэдлэг шалгах ) дугаар түвшний шалгалтаар шалгаруулна.

6.1.1. Эссэ нь тухайн алба хаагчийн ажиллаж буй байгууллага, газар, хэлтэс, нэгж, тасагт тулгамдаж буй зөвхөн нэг асуудлыг хөндсөн, тухайн асуудлыг практикт шийдэх боломжтой байх.

6.1.1.а. Эссэг ажлын хэсгээс оролцогчдод тавигдах шаардлага хангасан алба хаагчдыг бүртгэж байгууллага тус бүрт эргэж мэдэгдсэний дараа буюу 2024 оны 02-

р сарын 07-ны өдрөөс 2024 оны 03-р сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд бичиж бэлэн болгоно.

6.1.1.б. Эссэг илтгэлд хөрвүүлэн (power point программ ашиглаж болно) 3 минутад хэлэлцүүлнэ.

6.1.2. Цэргийн бие бялдрын ерөнхий бэлтгэлжилт, нормативт дасгалыг насны ангиллаар авч шалгаруулна.

6.2. Тэмцээний хоёрдугаар шатанд байгууллага тус бүрээс шалгарсан 4-6 алба хаагчдыг нэг баг болгон багаар гүйцэтгэх 2 гэрийн даалгавар өгөх бөгөөд даалгаврыг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дараах байдлаар гүйцэтгэнэ.

Гэрийн даалгавар 1: Байгууллагаас шалгарсан баг Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд өөрийн байгууллагын 1 албан хаагчийг сонгож амьдрах орчинг сайжруулах сайн үйлсийн ажлыг нийт байгууллагын хамт олныг хамруулан зохион байгуулж нэмэлт оноо цуглуулна. (2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл)

Зөвлөмж: Байгууллагаас шалгарсан баг хийж гүйцэтгэсэн ажлын тухай мэдээллийг (амьдрах орчинг сайжруулаагүй байх үеийн зураг, видео бичлэг сайжруулсны дараах зураг, видео бичлэг нийт гаргасан зардал, хүн хүч, байгууллагын албан хаагчдын оролцоо гэх мэт мэдээллийг багтаасан нэг пост бэлдэнэ) Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд байрлуулах бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 17 цаг 00 минутын байдлаар зөвхөн дээрх цахим хуудсанд хандсан хандалт (лайк)-аар дүгнэж 0-10 хүртэлх оноогоор дүгнэнэ. (оролцоогүй байгууллагын алба хаагчдад оноо өгөхгүй)

Гэрийн даалгавар 2: 1 дүгээр шатанд хэлэлцүүлсэн нийт илтгэлүүдээс практикт шийдэх боломжтой нэг асуудлыг багаараа сонгож тухайн асуудлыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд байгууллага дээрээ хэрэгжүүлж, хүрсэн үр дүнгээр нь шүүгчид 0-10 хүртэлх оноогоор дүгнэнэ.

(Оролцоогүй байгууллагын алба хаагчдад оноо өгөхгүй)

6.2.1. Дээрх хоёр гэрийн даалгаврын танилцуулгыг цаасаар бэлтгэж нотломжийн хамт ажлын хэсгийн нарийн бичгийн даргад 2024 оны 08 дугаар сарын

10-ны өдрийн дотор ирүүлснээр ажлын хэсэг хэлэлцэж дүгнэнэ. (Материал ирүүлэх цахим хаяг: [moduchin@gmail.com](mailto:moduchin@gmail.com), мэдээлэл авах утас 86973607)

6.3. Хоёрдугаар шатны тэмцээнийг дараах төрөлтэйгөөр зохион байгуулж дүгнэнэ.

6.3.1. Цэргийн дүрмийн мэдлэг (тусгайлан бэлтгэсэн программ ашиглан 30 минутын хугацаанд тест бөглөж, 1 алба хаагч 10 минутын хугацаанд цэргийн жагсаалын дүрэм, жагсаал командлах ур чадвараар өрсөлдөнө.) 10.0 оноо,

6.3.2. Бие бялдрын бэлтгэлжилт (тусгайлан бэлтгэсэн олон даалгавар бүхий богино зайны бартаат замыг туулна) 20.0 оноо;

6.3.3. Асуудал шийдвэрлэх чадварын болон сэтгэл зүйн тест (Урьдчилж бэлтгэсэн асуулт, бодлогыг 30 минутад бодно.) 10.0 оноо;

6.3.4. Галт зэвсэг ашиглах (Пм, АКМ гар бууны буудлагын дасгалыг дүрмийн дагуу гүйцэтгэнэ) 20.0 оноо;

6.3.5. Хэрэглээний программын мэдлэг (Microsoft word 2016, Microsoft excel 2016 програмууд дээр урьдчилж бэлтгэсэн өгөгдлийг дуурайж үйлдэх болон excel-д энгийн хэрэглээний томъёо ашиглаж, үйлдэнэ) 10.0 оноо;

6.3.6. Хууль, эрх зүйн мэдлэг (Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын нийтлэг хэрэглээний хуулиар бэлтгэсэн тестийг 50 минутад бөглөнө.) 10.0 оноо;

6.4. Удирдамжийн 6.1-т заасан тэмцээн, шалгалт тус бүр тусгай зааврын дагуу явагдана.

6.5. Удирдамжийн 6.1-т заасан тэмцээн, шалгалт бүрийн дүнг их онооны системээр дүгнэх бөгөөд 1-100 оноогоор жагсааж, хавсралтаар батлагдсан үнэлгээний хүснэгтийн дагуу уралдааны төгсгөлд нийлбэр дүнгээр байр эзлүүлнэ. (Шагналт байр эзэлсэн алба хаагчдын оноо тэнцсэн тохиолдолд ажлын хэсгээс нэмэлт даалгавар гүйцэтгүүлнэ)

6.6. Тэмцээн тус бүрийг зохион байгуулж буй байгууллага мэргэшсэн шүүгчээр шүүлтийг хийлгэнэ.

6.7. Ажлын хэсэг шалгаруулалтыг явуулж эцсийн дүнг Хэнтий аймгийн Засаг даргад танилцуулна.

#### Долоо. Шагналын төрөл, хэмжээ

7.1. Шилдэг эрэгтэй, эмэгтэй офицер, ахлагчаар шалгарсан алба хаагчдыг дараах байдлаар шагнана.

7.1.1. Эрэгтэй, эмэгтэй офицерын тэргүүн байр тус бүрт – Өргөмжлөл, 5,000,000 төгрөг,

7.1.2. Эрэгтэй, эмэгтэй ахлагч тэргүүн байр тус бүрт – Өргөмжлөл, 5,000,000 төгрөг;

7.1.3. Хоёр гэрийн даалгаврын нийлбэр оноогоор хамгийн өндөр дүгнэгдсэн багт - 3,000,000 төгрөг,

7.2. Тэмцээний 2 дугаар шатанд шалгарсан оролцогч тус бүрд Засаг даргын тамгын газраас 500,000 төгрөгийн мөнгөн урамшуулал, талархал олгоно.

ХЯНАСАН:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНТУУГА

БОЛОВСРУУЛСАН:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН  
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН,  
ЦАГДААГИЙН АХЛАХ ДЭСЛЭГЧ

Э.МОДУЧИНТУЯА